

ЗАЛУУЧУУДЫН НИЙГЭМ-СОЁЛЫН КАПИТАЛЫГ ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ХАНДЛАГААР ШИНЖЛЭХҮЙ

*Ш.Оюунханд доктор, профессор
МУИС, ШУС-ийн Социологи Нийгмийн ажлын тэнхим
0000-0001-7054-6162*

*П.Цэрэнбазар доктор, дэд профессор
МУИС, ШУС-ийн Социологи Нийгмийн ажлын тэнхим
0000-0002-4117-685X*

*Веренич Мария
БНБУ-ын Үндэсний шинжлэх ухааны академи
Философийн салбарын эрдэм шинжилгээний ажилтан*

Abstract: *Youth is a very important social group depending on their age and lifestyle. Because of their social role, they have been the main object of social research since the beginning of the twentieth century. Mongolian sociologists have studied young people's consumption, political and social participation, economic condition, family and family planning, and values. But for now, there is still a missing cultural heritage value study for young people. Especially the statues and other art creatives such as movies, museums, and art galleries created in the soviet era and before. The writers of this article are rooted in their research topic from the socio-economic and cultural-historic side based on Bourdieu, Foucault, and Fukuyama. As a result of the youth-related research review, it is important to capture the current situation of young people's cultural heritage.*

Keywords: *young, young adult, adolescence, cultural heritage, value*

Залуучууд хэмээх ойлголтын динамик шинж

Залуучууд гэсэн ойлголтыг ерөнхий утгаар нь нэвтэрхий толь бичигт “насны шинж байдал, нийгмийн байр суурийн онцлог зэрэг нийгмийн байгууламж, соёл, нийгэмшлийн зүй тогтол, хүмүүжлийн онцлогоос улбаалан нийгэм-сэтгэл зүйн бүлэг” гэсэн байдаг²⁵. Хүн ам зүй, антропологийн судалгаанд анх “насны бүлэг” гэсэн ойлголтыг хэрэглэсэн байна. А.Радклифф Браун, А.Принс нарын антропологичид “насны анги” болон “насны цогц бүрдэл” гэсэн ухагдахууныг эмпирик судалгааны үр дүнг нэгтгэхэд ашиглажээ²⁶. Америкийн социологич Р.Линтон “насны ангилал” хэмээх ухагдахууныг социологид хэрэглэхдээ нийгмийн бүтцийн судалгаанд нас, хүйсийн онцлогийг тооцох санааг дэвшүүлсэн.²⁷ Германы социологич Г.Шельски “залуучуудыг хүүхдийн дүрээс дэвшин гарсан боловч насанд хүрэгчдийн дүрийг бүрэн эзэмшиж амжаагүй хүмүүсийн амьдралын зан төлөвийн онцгой үе шат” гэж үзсэн. Дээрх тодорхойлолтуудыг нэгтгэн авч үзвэл залуучууд бол нас хийгээд үндсэн үйл ажиллагааныхаа хүрээгээр уялдсан нийгмийн бүтэц дэх нэгдмэл ашиг сонирхолтой бүлэг хүмүүс юм. Эдгээр хүмүүс нийгэм хүн ам зүйн бүрдлийн тухайд нас, үйл ажиллагаа, оршин суугаа газраараа харилцан адилгүй байна. Үүн дээр тулгуурлан тэдний ухамсар, ашиг сонирхол өөр өөр байдаг ба нийгмийн хөгжлийг даган улам бүр олон янз болсоор байна.

Хорьдугаар зууны турш “залуучууд” гэх томъёолол ихээхэн өөрчлөгдсөөр ирсэн ч насаар тодорхойлогдох нийгмийн байр суурь, чиг үүрэг, дүр гол хэмжигдэхүүн хэвээр байна. “Залуучууд” гэдэг өвөрмөц үзэгдлийн онцлогуудын талаар, юуны өмнө залуучуудын насны хүрээ хязгаарын талаар төрөл бүрийн үзэл санаа бий. Тухайлбал, НҮБ-ын 1981 оны Ерөнхий Ассамблейн хуралдаанаар 15-24 насны хүмүүсийг залуу гэж үзнэ гэсэн томъёоллыг соёрхон баталсан бөгөөд 19

²⁵ www.un.org/events/youthday/sg.shtml

²⁶ Советский энциклопедический словарь. Издательство Советская энциклопедия. М., 1980. Хууд 833

²⁷ Age and sex categories. Linton aR. American Sociological Review, 1942 No7, P..589-603

нас хүртэл “өсвөр үе буюу adolescence”, 20-24 насны хүмүүсийг “залуу насанд хүрсэн буюу young adults” ангилалд хамруулсан юм. Монгол улсын хувьд 15-34 насны хүмүүсийг залуучууд гэсэн ангилалд хамруулж, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зорилгыг “төрөөс залуучуудын хөгжлийг дэмжих эрх зүйн үндсийг тогтоож, нийгмийн хөгжилд оролцох залуучуудын оролцоо, эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулах” гэж заажээ. Социологич Х.Гүндсамбуу, Д.Зоригт нар залуучуудын насны ангилал, үеийн ангиллыг өөр өөрсдийнхөө ангилсан байдаг ба энэ 1970-д оны сүүл үеэс 1987 онуудад тэдний ажилласан цуврал судалгаанаас гарсан дүгнэлт дээр үндэслэсэн болов уу.

Нөгөө талаас нь амьдралын мөчлөгийн тодорхой үе шатаар авч үзэх хандлага хүчтэй байна. Нийгэм дэх залуучуудын үүрэг, тэдний байр суурь хийгээд тэдгээрийн үйл ажиллагааны онцлог адил бус гэдгийг харгалзаж үзэх нь зүйн хэрэг юм. НҮБ үүнийг харгалзан залуучуудыг зөвхөн хүн амын насны бүлгээр төдийгүй мөн “хүүхэд нас дуусч хөдөлмөрийн үйл ажиллагаа эхлэхийн хоорондох шилжилтийн үе” гэж тодорхойлсон. Энэ үед залуучуудын нийгмийн байр суурь харилцан адилгүй боловч тэднийг хамрах үйл ажиллагааны үндсэн хүрээ сургууль, ажил, түр ажил зэрэгтэй холбоотой гэж үздэг.

Ингэж авч үзэхдээ залуучуудын нийгэмших хамгийн идэвхтэй цаг үеийн сэтгэхүйн онцлогийг анхаарах нь чухал. Нас гэдэг бол биологийн бодит зүй тогтол хэдий ч үүний үр нөлөө, туршлага тухайн түүхэн нийгэм, соёлын үйл явцтай шууд холбоотой байдаг. Нийгэм, улс төрийн онцлог үйл явц тухайн нийгмийн боловсролын түвшин, соёлын түвшин, хэм хэмжээтэй холбоотой байдаг. Иймд залуу үе гэдэг нийгэм, улс төр, соёлын байдлаас хамаарах хувьсагч байж болно. Энэ үүднээс авч үзвэл хамгийн өргөн дэлгэр, нийтийг хамрах ойлголт болох залуучуудыг нийгмийн нөлөө бүхий түгээмэл хөгжлийн үе шат хэмээн авч үзэж болно.

Залуучуудын нийгэм соёлын капитал ба үнэт зүйлийг судлах ач холбогдол

Английн социологич Кен Робертс нийгэмд тогтсон үзэл бодол, соёлын хэв маяг мухардалд орсон үед залуучууд тэднийг чиглүүлэх, шинэ хэв маяг, үнэт зүйлсэд чиглүүлдэг гэж үзсэн²⁸. ҮСХ-ны 2021 оны тоо баримтаар 15-34 насны залуучууд нийт хүн амын 29.8 хувь буюу 1,016,859 байна²⁹. дээр дурдсан хандлагаар үзвэл хүн ам зүйн энэ бүлэг нь насны хувьд (өсвөр үеийнхэн ба залуу насанд хүрэгчид) үйл ажиллагааны хувьд (суралцагчид, ажиллагчид), оршин суугаа газар байршлын хувьд (хот, хөдөөгийн) харилцан адилгүй хэв шинжийг агуулж байгаа.

Эдгээр ялгаатай мөн ижил төстэй хэв шинж нийгэм соёлын хувьд ямар түвшинд адилсал ба ялгаа үүсгэж байгааг соёлын өвд хандах хандлага, тэдгээр өгч буй үнэлэмжээр тодорхойлох оролдлогыг энэ өгүүллийн хүрээнд хийж үзлээ. Үнэлэмж гэдэг ойлголтыг хүмүүнлэгийн болон нийгмийн ухаанд тодорхой үзэгдлийн хүн, нийгэм ба соёлын ач холбогдлыг тодорхойлохын тулд нэлээд өргөн хэрэглэдэг. Үнэлэмж нь соёл-түүхийн, нийгэм-эдийн засгийн агуулгаар нөхцөлдсөн байдаг. Үүнтэй холбоотойгоор үнэлэмжийг уламжлал ба орчин үеийн нийгмийн нөхцөлийн нөлөө, тухайлбал, нийгэм даяаршиж байгааг тооцож үзэхгүйгээр авч үзэх боломжгүй. Түүнчлэн залуу нас бол зөвхөн биологийн үйл явц биш, хүн амын болон нийгмийн нөхөн үржихүйтэй салшгүй холбоотой нийгмийн үйл явц юм. Энэ утгаараа залуучууд нь:

- нийгэм ба улс орны хүрсэн хөгжлийн түвшинг өвлөдөг.
- тодорхой үнэлэмжийн чиг баримжаа ба амьдралын туршлага дутмагаараа ялгардаг,
- нийгэмшил, дасан зохицолт ба хүмүүжлийн объект, субъект болдог.
- эдийн засгийн санаачилгын шилжилтэд голлон оролцогч, нийгэм, улс төрийн харилцаанд бүрэн бус оролцогч

²⁸ Kenneth Roberts. Contemporary Society and the Growth of Leisure, 1978

²⁹ https://www.1212.mn/mn/statistic/statcate/573051/table-view/DT_NSO_0300_071V3

- нийгмийн бүлгийн хувьд улс орны нийгэм – эдийн засгийн хөгжил сэргэлтийн эх булаг

Эдгээр үзэл санаанууд залуучуудын асуудлыг судлах тал, аспектууд ямар өргөн хүрээтэй болохыг харуулж байгаа юм. Өмнө дурдсанчлан өгүүллийн хүрээнд залуучуудын соёлын өвд хандах хандлага нь тэднийг нийгэм – эдийн засгийн, соёл – түүхийн бүтээгдэхүүн болохын зэрэгцээ үүнийг хэрхэн өв болгон авч, өөрсдийн туршлага, үнэлэмжид шингээж, нийгмийн капиталгаа бүтээхдээ ашиглаж буй нь сонирхолтой бөгөөд ач холбогдолтой гэж зохиогчид үзэж байгаа юм.

Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрт залуучуудын нийгмийн оролцоог дэмжихэд соёлын өв хөшөө дурсгал, театр, кино, бүтээл туурвил, ном зэрэгт хандах залуусын хандлага ба хэрэглээг үнэт зүйлсийн хандлагаар судлах асуудал чухал байгаа юм. Учир нь монгол улсын түүхэнд залуучуудын асуудлаар судалгаа шинжилгээний ажил хийж, үр дүнг хэвлэн нийтэлсэн хугацаа дөрвөн арванаар хэмжигдэж байгаа ч соёл – түүхийн агуулга туйлын бага судлагджээ. Залуучуудын асуудлаар сүүлийн 10 жил хийгдсэн судалгааны агуулгыг харуулбал,

1. Хуучнаар ШУА, ФСЭЗХ-ийн Социологийн сектор (2012) Монголын залуучуудын нийгмийн дүр төрх (XX-XXI зууны зааг үе) судалгааны эмхэтгэл “Залуучуудын амьдралын зорилго, үнэт чанарын өөрчлөлт”³⁰ сэдэвт суурь судалгааны ажлын хүрээнд хийгдсэн бөгөөд залуучуудын социологи хүн ам зүйн байдал, залуучуудын хэрэгцээ, амьдралын зорилго үнэлэмж, залуучуудын хөдөлмөрийн хандлагад гарч буй өөрчлөлт, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдлийн шалтгаан, залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, залуучуудын гэрлэлт, гэр бүл төлөвлөлт, залуучуудын боловсрол, мэргэжил сонголтын зарим асуудал, залуучуудын гажууд зан төлөв гэсэн нийт 8 бүлгийн хүрээнд залуучуудын нийгмийн дүр төрхийг судлан тодорхойлжээ.
2. Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэнгийн захиалгаар 2020 онд Хараат бус судалгааны хүрээлэнгийн гүйцэтгэсэн “Залуучуудын санал бодол”³¹ судалгаанд нийгэм улс төрийн нөхцөл байдал, авилга, цар тахал, залуучуудын улс төрийн идэвх оролцоо, нийгмийн хөгжлийн чиг хандлага ба олон улсын харилцааны асуудлыг голлон хөнджээ.
3. Судалгаа зөвлөх үйлчилгээний Эс Ай Си Эй ХХК мөн 2020 онд “Монголын нийгмийн үе хоорондын судалгаа”³² сэдэвт судалгааны ажлыг удирдаж явуулжээ. Уг судалгааны зорилго нь монголын нийгмийн үе хоорондын ялгаа, онцлогийг тодорхойлох бөгөөд ач холбогдлыг нь улсын нийгэм, эдийн засгийн онцлогт тохируулан нийгмийн үеүд, үе хоорондын ялгаатай байдлыг тодорхойлсноор бизнесийн байгууллагууд, судлаачид, төрийн бодлого боловсруулагч нарт чухал ач холбогдолтой судалгаа бий болох юм гэж үзжээ.

Социологич доктор Ц. Пүрэв “Монголын нийгмийг социологиор шинжихүй” бодол, төсөөлөл, эргэцүүлэл³³ хэмээх эрдмийн бүтээлийн эмхэтгэлд дурьдсанчлан “Монголын нийгмийн бүлэг, нийтлэг, хувь хүмүүсийн амьдрал, зан төлөв, үнэлэмж тогтсон хандлага, сэдэлжилт өөрчлөгдөж төн тэдгээртэйг танин мэдэхийг эрмэлзэгч ШУ-ны салбаруудын судалгааны арга зүй, аргачлал, техник ч шинэчлэгдэж байна. 70-н насны сүүдэр зэрэгцэж буй миний амьдрал, судалгаа шинжилгээний арга барил, үзэл бодол төсөөлөл, эргэцүүлэл ч нийгмийн бодит байдлын өөрчлөлтийг даган хувьссаар иржээ” хэмээсэн нь хурдацтай өөрчлөгдөж буй нийгмийн үзэгдэл үйл явц, тэр дундаа “залуу нас” хэмээх ойлголтын харьцангуй шинж, дамжин өнгөрөх чанар, амьдралын хүрдэн тойргийн хувьд өнөөдрийн хүүхдүүд маргаашийн залуучууд, өнөөгийн ахмадууд өчигдрийн залуус гэж харвал харьцуулсан шинжилгээ хийх, өв залгамж холбоог ойлгох нийгмийн амьдралын үнэ цэнэ утга учрыг

³⁰ ШУА, ФСЭЗХ-ийн Социологийн сектор (2012) Монголын залуучуудын нийгмийн дүр төрх (XX-XXI зууны зааг үе)

³¹ БНОУХ, ИРИМ, Залуучуудын санал бодол

³² SICA, Монголын нийгмийн үе хоорондын судалгаа

³³ Ц. Пүрэв “Монголын нийгмийг социологиор шинжихүй” бодол, төсөөлөл, эргэцүүлэл 2013

ойлгох, бүтээхэд сургамжтай төдийгүй хөгжлийн залгамжлал мөнхүү хувьсан шинэчлэгдэх шинж чанар, логикийг ойлгох, судлахад гарцаагүй чухал гэж харж байна.

Залуучуудын нийгэм-соёлын капиталыг үнэт зүйлс, үнэт чанарын хандлагаар судлах онол-арга зүйн, хэмжилт хийх гол шалгуур болон үндэслэлүүд нь:

1. Нийгмийн ШУ-ны олон салбарын заагт залуучуудын нийгэмшилд нийгэм-соёлын хүчин зүйлс (бүтээлч, урлаг) эдийн засагтай хэрхэн уялдаатай болох эдийн засаг, бүтээлч үнэ цэнэ, соёлын үр өгөөжийг хэрхэн бий болгож болохыг шинжлэх нь орчин үеийн нийгмийн капиталыг хэмжих чухал үзүүлэлт юм.
2. Өнөөдөр залуучуудын ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйлсийн чиг хандлагын хүрээнд урлаг, гоо зүй, соёлын өв, соёлын бүтээгдэхүүнд хандах хандлага, үнэ цэнэ утга учрыг судлах, түүний өөрчлөлт хөгжлийн динамикийг хэмжих нь нийгмийн залгамж холбоо, хөгжлийг ойлгох түлхүүр мөн.
3. Нийгэм-улс төрийн тогтолцоог өөрчлөх үйл явцыг туулж буй улс орнуудад (Беларусь, Монгол улсууд) түүхэн болон соёлын баялаг өв, соёлын дэд бүтэц оршин байдаг ч дэс дараатай менежмент, ул суурьтай судалгаанд суурилсан бодлого, хангалтгүй байгаа агаад, дээрх асуудлыг НШУ-ны салбар дундын судлагдхууных нь хувьд шинжлэх, энэ чинээгээрээ хөгжилд шинэ түлхэц болох алхам юм.
4. Соёл, гоо зүйн уламжлалт болон шинэлэг талбаруудыг (номын сан, музей, театр, кино театр гэх мэт) харгалзан мэдээллэх, даяаршлын сорилтуудын хүрээнд орчин үеийн залуучуудын урлаг, гоо зүйн соёлд оролцох оролцоо, хэрэгцээ ба хандлагын харьцуулсан систем-функциональ дүн шинжилгээ хийх, үнэт зүйлсийн хандлагаар судлах, урлагийн төслүүд, хувийн соёлын санаачлагууд: орчин үеийн соёлын бүтээлч кластеруудыг судлах, соёлыг хөгжүүлэх, өнөө үед урлаг, гоо зүйн соёлын хөгжлийг урьдчилан таамаглах социологиор шинжих нь мэдлэгийн архив, залгамжлалын логикийг ойлгоход нэн тустай хэмээн үзэж байна.

Нийгмийн бодит нөхцөл нэн ялангуяа дэлхий нийтийн хэмжээнд сүүлийн үед өрнөж буй үйл явдлууд цар тахал, гибрид дайн, эрх мэдэл, эдийн засгийн хориг, глобальчлал зэрэг ойлголтууд нь хэдийн хүн төрөлхтөний түүхэнд байсаар ирсэн ч шинэ утга санаагаар баяжин бидний толгойд нэгэнт бүрэлдэн тогтсон зүйлийн дахин шинээр харах, амьдралын үнэ цэнэ, утга учир, ертөнцийг үзэл үзэл, үнэлэмж дүгнэлтэд, наснаас хамааран харилцан адилгүй нөлөөлсөөр байгаа нь дамжиггүй билээ. Энэ нь ялангуяа “Залуучууд” хэмээх ойлголтыг судлах хандлагад судлаачийн хувийн амьдралын орон зай, туршлага, замналд онцгой нөлөө үзүүлж, шүүмжлэх, бахархах зэрэг төрөл бүрийн холимог мэдрэмжүүдийг бий болгож байгаа нь маргашгүй юм.

1. Монголын нийгмийн социаль өөрчлөлт бүтээлийн “Нийгмийн оюун санааны өөрчлөлт” хэмээх 3-р бүлэгт эрхэмлэх зүйлсэд гарч буй өөрчлөлт, итгэл үнэмшил, соёл урлагт гарч буй өөрчлөлтүүдийг авч үзсэн нь социологийн судалгаа хэмжилт талаасаа ч, амьдралын үнэ цэнэ залгамж холбооны философийг ойлгох талаасаа ч нэн үнэ цэнэтэй юм.
2. Нийгмийн капиталын хэмжих онол арга зүйн тулгуур нь сүлжээний болон нийгмийн итгэлцэл хэмээх цөм ойлголтуудаар нөхцөлддөг талаар Ф. Фукуяма, нийгмийн капиталын үзэл санаа нь соёлын капитал болон хабитусаар тодорхойлогддог тухай П.Бурдьё, түүнчлэн түүх бол зөвхөн өнгөрсөн үед хамрагддаггүй бид бүгдээр орчин үеийн түүхийн бүтээгчид болох талаар М.Фуко нар пост модернист арга зүйгээр шинжилсэн байдаг.

3. Дээрх үзэл санаануудад тулгуурлан орчин цагийн Залуучуудын урлаг, гоо зүй, уламжлалт соёлд хандах хандлагыг тэдний үнэт зүйлсийн чиг баримжаа, даяаршил, интеграцийн чиг хандлагын хүрээнд тодорхойлох;
4. Нэн ялангуяа хөгжлийн туулсан замналын хувьд ойр дөт улсуудын соёлын салбарын хөгжлийн чиг хандлагын хүрээнд залуучуудын урлаг, гоо зүй, уламжлалт соёлд хандах хандлагын нийгэм-соёлын үзэл баримтлалыг боловсруулах;
5. Нийгэм-Соёлын салбарын өнөөгийн байдлыг харгалзан соёлын бүтээгдэхүүний хэрэглээнд залуучуудын хандлагын чанарын шинжилгээ хийх;
6. Залуучуудын урлаг, гоо зүйн соёлд хандах хандлагад нөлөөлж буй объектив болон субъектив хүчин зүйлсийг үнэт зүйлсийнх нь хүрээнд илрүүлэх;
7. Соёлын хөгжлийн шинэлэг хэлбэрүүдийн бүрэлдэн, хувьслын бүтцийн болон динамик шинж чанар, түүхийн дурсгал соёлын өвийг сэргээн засварлах зорилгоор соёлын салбарын материаллаг, санхүү, хөдлөх ба үл хөдлөх, хүн, боловсон хүчин, мэдээллийн нөөц) хангагдсан байдалд дүн шинжилгээ хийх.

Эдгээр онол арга зүйн үндэслэлийн дагуу өгүүллийн зохиогчид өөрсдийн эхлүүлж буй залуучууд соёлын өв, түүхэн дурсгалт бүтээлийг хэрэглэх, үнэлэх байдал, түүнд өгч буй ач холбогдлоор дамжуулж нийгмийн үе хооронд соёлын залгамжлал ба нөхөн үйлдвэрлэл ямар түвшинд явж байгааг судлах судалгааны ажлаа эхлүүлж байна. Тус судалгааны ажлын онцлог нь монгол ба беларус улсын залуучуудын жишээн дээр судалж харьцуулалт хийн, пост социалист орнуудын залуучууд социалист систем нуран унаснаас хойш 30 жилийн дараа тухайн нийгмээс үлдсэн соёлын өв дурсгалыг хэрхэн үнэлж байгаа, тэдгээр нь социализмаас өмнөх үеийн сонгодог соёлын өвүүдтэй харьцуулахад ямар байр суурийг эзэлж байгаа, эцэст нь соёлын өв, дурсгал нь залуучуудын оюун сэтгэхүйд хэрхэн нөлөөлж, амьдралын зорилго, үнэт зүйл бүрэлдэн тогтоход үзүүлж буй нөлөөллийн хэмжих ач холбогдолтой юм.

Ном зүй

1. Ц. Пүрэв “Монголын нийгмийг социологиор шинжихүй” бодол, төсөөлөл, эргэцүүлэл 2013
2. ШУА, ФСЭЗХ-ийн Социологийн сектор Монголын залуучуудын нийгмийн дүр төрх (XX-XXI зууны зааг үе), 2012
3. БНОУХ, ИРИМ, Залуучуудын санал бодол, 2020
4. SICA, Монголын нийгмийн үе хоорондын судалгаа, 2020
5. Совестский энциклопедический словарь. Издательство Советская энциклопедия. М.,1980. X.833
6. Age and sex categories. Linton R. American Sociological Review, 1942 No7, P..589-603
7. Kenneth Roberts. Contemporary Society and the Growth of Leisure, 1978
8. www.un.org/events/youthday/sg.shtml
9. https://www.1212.mn/mn/statistic/statcate/573051/table-view/DT_NSO_0300_071V3